



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/238

Чингис хот

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 09 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн бүтцийг шинэчлэн тогтоож Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар болгон өөрчилсөнтэй холбогдуулан хавсралтад дурдсан газруудыг эзэмшүүлсүгэй.

2. "Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар"-ын эзэмшиж буй газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар /С.Эрдэнэжаргал/-т үүрэг болгосугай.


5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2013 оны А/150 дугаар захирамжийн хавсралтын 2, 3 дахь хэсэг, 2013 оны А/515 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



06
Аймгийн Засаг даргын 2018 оны
дугаар сарын 28 өдрийн А/238
дугаар захирамжийн хавсралт



**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ЭЗЭМШИЖ БАЙГАА ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ, ЗОРИУЛАЛТ**

д/д	Иргэний эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Талбайн хэмжээ /м ² /	Байршил	Газар эзэмшлийн зориулалт	Хугацаа /жил/
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	9076913		200	Хэрлэн сум, 2-р баг, Тэмүүжингийн гудамж	Үйлчилгээ	46
2	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	9076913		1643	Хэрлэн сум, 1-р баг, Тэмүүжингийн гудамж	Төрийн үйлчилгээ	47
3	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	9076913		2500	Хэрлэн сум, 1-р баг, Нисэх буудлын зүүн талд	Төрийн үйлчилгээ	10